

## Оршихуйн нэгдэл: Монгол уламжлал дахь байгалийг үзэхүй

**Пүрэвдоржийн Мягмарсайхан**, *магистр*  
*Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн*  
*Улаанбаатар, Монгол Улс, [myagmarsaikhanp@mas.ac.mn](mailto:myagmarsaikhanp@mas.ac.mn),*  
*<https://orcid.org/0009-0001-5288-0340>*

### Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

### Түлхүүр үгс

*Оршихуйн нэгдэл,*  
*уламжлал,*  
*нүүдэлчдийн соёл,*  
*шашин шүтлэг,*  
*байгаль орчин, хууль*  
*ёс, орчин үе*

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд Монголчуудын байгальтай хүйн холбоотой амьдралч ирсэн уламжлалыг “оршихуйн нэгдэл” гэсэн үзэл санааны хүрээнд авч үзсэн. Судалгаанд нүүдэлчдийн байгаль орчинтой тогтоосон зохицсон, хүндэтгэлд суурилсан харилцааг зан заншил, хориотой зүйлс, өдөр тутмын дадал зуршил, итгэл үнэмшил, хууль эрх зүйн уламжлалын хүрээнд шинжилсэн. Шашин шүтлэг, бөө мөргөл, тэнгэр шүтлэг, буддизм зэрэг уламжлалт мэдлэг, ёс суртахуун, амьдралын хэв маяг нь байгаль орчныг зөвхөн ашиглах объект бус, хүндэтгэх ёстой амьд оршихуй гэж үздэгийг харуулж байна. Мөн философийн үзэл санаа, орчин үеийн гүний экологи (deep ecology)-тай харьцуулан судалснаар Монголчуудын уламжлалт экологийн ухаан өнөөгийн уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал алдагдах, газрын доройтол зэрэг асуудлуудад хэрхэн ач холбогдолтой болохыг онцлов.

## Unity of existence: Mongolian traditional views on nature

**Myagmarsaikhan Purevdorj**, *MA*  
*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences*  
*Ulaanbaatar, Mongolia, [myagmarsaikhanp@mas.ac.mn](mailto:myagmarsaikhanp@mas.ac.mn),*  
*<https://orcid.org/0009-0001-5288-0340>*

### Keywords

*Unity of existence,*  
*tradition, nomadic*  
*culture, religion,*  
*environment, legal*  
*norms, contemporary*  
*era*

**Abstract:** This article examines the Mongolian tradition of living in close connection with nature through the concept of the “unity of existence.” The study analyzes the harmonious and respectful relationship that nomadic communities have maintained with their natural environment, as reflected in customs, taboos, daily practices, beliefs, and legal traditions. Traditional knowledge systems—including religion, shamanic practices, Tengri worship, and Buddhism—demonstrate that nature was regarded not merely as a resource to be used but as a living entity deserving respect. By situating this worldview in dialogue with philosophical ideas and contemporary deep ecology, the study highlights how traditional Mongolian ecological wisdom can offer insights for addressing modern environmental challenges such as climate change, biodiversity loss, and land degradation.

© The Author(s), 2025



## I. ОРШИЛ

Монголчуудын туулж ирсэн амьдрал, зан заншил, соёл нь байгальтай харьцах элгэмсэг, хүмүүнлэг арга хандлагыг олон зууны туршид хадгалан бидний үед хүрч ирсэн. Нүүдэлчин монголчуудын хувьд хүн өөрийгөө байгалиас ангид авч үзэх аргагүй байсан ба эх байгаль газар нутгийн онцлогтоо тохирсон аж ахуй эрхлэн, хүн байгальтайгаа хүнлэг харьцаж, байгалиа шүтэж, дээдэлж, нэгдэж, оршин тогтнож буй бүхнийг байгалийн жам хуулийн дагуу сэтгэж ойлгож ирсэн байна. Тиймээс хөрс ус, байгаль дэлхийгээ хайрлаж хамгаалах тухай сургаалийг олон үе дамжуулан захиж, даган мөрддөг байжээ.

Аливаа иргэншил, соёлын хөгжлийн явцад хүн байгалиасаа холдсоор ирсэн байдаг. Харин нүүдэлчдийн туулж ирсэн амьдрал, соёлын үйл ажиллагаа нь байгальтай харьцах элгэмсэг, хүмүүнлэг арга хандлагыг олон зууны туршид хадгалж ирсэн онцлогтой.

Монголын уламжлалт соёл, сэтгэлгээ нь байгальтай харилцах хандлагаараа онцлог бөгөөд хүн, байгалийн хоорондын нэгдлийг илэрхийлдэг. Энэхүү өгүүлэл нь “оршихуйн нэгдэл” хэмээх ойлголтыг Монгол уламжлал дахь байгальд хандах хандлага, нүүдэлчдийн амьдралын хэв маяг, шүтлэг, зан заншил, соёл, түүхэн уламжлалаар нь дамжуулан авч үзэхийг зорьсон болно. Чингэхдээ уламжлалт ардын мэдлэгийн хэлбэрүүдийг зан заншил, хорио цээр, амьдралын хэв маяг байгалийг хайрлах ухаан, шүтдэг, шүтэн бишрэхүй, түүхэн уламжлал эх сурвалж хэмээн ангилж тухай бүрт өөрийн дүгнэлтийг тэмдэглэж, энэ бүхэн дээрээ үндэслэн онолын хүрээ буюу оршихуйн философи нь түүхэн явцдаа хэрхэн тавигдаж ирснийг тойм байдлаар авч үзэж, өнөө цагт монголчуудад байгаль орчны хувьд тулгамдаж буй асуудлыг

хэлэлцүүлэх байдлаар судалгаагаа хийж, эцэст нь ерөнхий дүгнэлтээ гаргалаа.

## II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд Монголчуудын уламжлалт байгальтай харилцах үзэл, оршихуйн нэгдлийг судлахдаа герменевтик арга голчлон хэрэглэсэн. Судалгаанд түүх, соёл, шашин, ёс заншил, хууль эрх зүйн эх сурвалжуудыг нэгтгэн задлан шинжилж, нүүдэлчдийн байгаль орчинтой зохицсон, хүндэтгэлд суурилсан харилцааг тодорхойлсон. Мөн Аристотель, Аквин, Спиноза, Кант, Хайдеггерийн философийн санаа болон орчин үеийн гүний экологи (deep ecology)-ийн үзэл санааг харьцуулсан. Судалгааны явцад уламжлалт үзэл санаа, орчин үеийн экологийн асуудлуудын хоорондын уялдаа холбоог шинжилж, түүх, философи, экологийн мэдлэгийг нэгтгэн синтез хийсэн. Ингэснээр Монголчуудын байгальд хандах, уламжлалын ач холбогдлыг орчин үеийн бодлого, боловсрол, нийгмийн үнэт зүйлст нэгтгэн, хүн ба байгаль хоорондын зохицол, нэгдмэл оршихуйн боломжийг авч үзсэн.

## III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нүүдэлчин монголчуудын хувьд байгальтайгаа хүйн холбоотой хэмээн сүслэж, ухаарч, сэтгэж ирснийг дараах байдлаар авч үзэж болох юм.

**Зан заншил, хорио цээр:** Монголчуудын хувьд байгаль орчин, хөрс шороогоо нандигнах үзэл нь хорио цээрийн бүтэл бүтэн тогтолцоонд түшиглэж байсан. Хөрс ус ургамал амьтанд зүй бусаар хандахыг нийтээрээ жигшиж тэр нь ёс суртахууны зэмлэл шүүмжлэлийн олон хэлбэрээр илэрч байсан. Үүнд: хөрс, ус, ургамал, амьтан, хүн гэсэн орчин амьдралын шүтэлцээний арвин их мэдлэгтэй байсан ба энэ шүтэлцээ эргээд харилцаа болох учраас байгальтай зүй зохистой

харилцах нь монголчуудын амьдралын салшгүй хэлбэр байсан. Жишээ нь хөрс онгиловол газар шороо шимээ алдаж ургамалын бүтэц өөрчлөгдөж, бэлчээр сүйдэнэ. Үүнийгээ (“лус догширч” газар хөдлөнө, ган зуд салхи шуурга болно) Булаг шанд голын хөвөө, усны эхийг цэвэр байлгах, энэ усанд бохир сав суулга хийж болохгүй ус татарч ширгэж үгүй болно. Нялх ногоо цэцэг навч таслах, онцгой ургасан мод, бут сөөгийг огтлохыг цээрлэдэг байсан, амьтны үүр, хэвтэрийг эвдэхийг хориглодог, ан агнахдаа усанд орж яваа болон хээлтэй амьтныг агнадаггүй, шувууны өндөгөнд сүүдрээ хүргэж болохгүй хэмээн хориглон цээрлэх зэрэг нь эрхэмлэн хүндлэх, хайрлан энэрэх үзлийг харуулж байсан. Энэхүү хорио цээрийн үзэл санаа нь байгалын тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх, зүй зохистой ашиглах, хойч үедээ бүрэн бүтнээр нь хадгалан өвлүүлэх гэсэн тогтвортой үзэл санааг агуулж байжээ. Монголчуудын үзэлд байгаль нь зүгээр нэг материаллаг орчин биш, харин амьд, эзэнтэй оршихуй байж ирсэн. “Лус догширно”, “ус ширгэнэ”, “газар хөдлөнө” гэх мэт ойлголт нь байгаль өөрөө хариу үйлдэл үзүүлдэг субъект хэмээн хүлээн зөвшөөрч буй онтологийн байр суурь юм. Хорио цээрийн тогтолцоо нь байгальд хандах ёс суртахууны хэм хэмжээ юм. Ургамал, амьтан, ус, хөрсийг хөндөх бүрд зөвшөөрөгдөх хязгаар бий. Энэ хязгаар нь зөвхөн практик үр дагавар бус, ёс суртахууны хариуцлагаар илэрдэг. Байгальд хүндэтгэлтэй хандах нь зөвхөн “сайн үйл” биш, харин ёс суртахууны үүрэг юм. Хүн, байгаль хоёрын харилцаа нь шүтэлцээ, тэнцвэр, нэгдэл, харилцан хамаарал дээр суурилдаг. Байгальд хүндэтгэлгүй хандах нь зөвхөн байгальд биш, өөртөө, үр хойчдоо, оршихуйн утга учирт халдах үйлдэл болдог. Тэгэхээр монгол уламжлалт мэдлэгт байгаль нь хэрэглээний объект бус, ёс суртахууны

субъект хэмээн хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд энэ нь байгальтай харилцах хариуцлагатай хандлагын үндэс болж ирсэн байна.

**Амьдралын хэв маяг, байгалиа хайрлах арга ухаан:** Монголчуудын нүүдэлчин ахуй нь байгальд ээлтэй, тэнцвэрт байдлыг хадгалах ухаан дээр суурилсан. Малын бэлчээрийг сэлгэх, улирлын дагуу нүүдэллэх, байгалиас авч хүртэж буй бүхий л хишигээ ихэд хүндэтгэлтэй хүртэж ирсэн нь экосистемийн тогтвортой байдлыг хангах уламжлалт ухаан байсан. Үүнийг өдөр тутмын амьдралдаа анхаарч ирсэн нь атар шил, аглаг уул ялгалгүй тааваараа нүх малтахыг цээрлэдэг бөгөөд чухал хэрэглээнд малтсан нүхийг ч хэрэглэж барвал их бага гэж ялгалгүй заавал тэгш сайхан бөглөж тавьдаг. Түлээ түлш түүхдээ хатаж хугарсныг нь авахаас биш, ургаа модны салаа мөчрийг авдаггүй. Шивээ модыг авахдаа ургаж гүйцсэнийг нь алхалж огтолдог биш нялх нялзрайг нь хөнддөггүй. Ан гөрөө хийхдээ намар өвлийн ан сайтай улирлаар голдуулдаг бөгөөд хожмын үржил төлжлийг анхаарч хүрээ ав хийхдээ ч зохих тоогоор үлдээдэг. Хөхүүл араатан, хээлтэй араатан, нялх зулзага ба өндөг дарсан жигүүртэн жич, ховор чухаг араатан жигүүртнийг агнахыг цээрлэдэг. Монголчууд хорхой шавжийг зугаацан егүүтгэх ба тарчлаахыг цээрлэдэг, тарчилгаж хороовол амьтны амийг хороосонтой адил нүгэл болно гэдэг. Үрэл, мойл, гүйлс мэтийн зэрлэг жимсийг түүхэд ч боловсорсоныг л түүдэг бөгөөд салаа намааг нь тасдаж хугалдаггүй. Уул усыг харааж зүхэх буюу гол усанд шээж баах, юм угаасан бузар усаа цутгах ба утгаж авсан усаа буцааж хийхийг чанга цээрлэдэг. Ээрэм тал, эзгүй ууланд ганц хоёроороо отор суулаа ч гэсэн үнс хогоо хамаа намаагүй хийсгэж хаядаггүй. Шилжиж нүүж явахдаа ч гал цогоо дарж нутаг бууриа гялтайтал цэвэрлээд сая

явдаг. Монголчууд бие биеэ ингэж шаарддагаар үл барам үр хүүхдэдээ ч багаас нь ингэж хийхийг сургадаг. Хэрэв зөрчвөл чанга донгодон шүүмжилж огтхон ч найр тавьдаггүй” (Монгол үйлийн нэвтэрхий толь, 2020) хэмээн Монгол зан үйлийн нэвтэрхий толь. Оюуны боть бүтээлд авч үзжээ. Энэ уламжлал нь өнөөдөр дэлхий нийт байгаль орчны хямралтай нүүр тулж буй үед үнэт сургамж, бодлогын суурь болж чадна. Байгальтай нэгдэн оршихуй нь ирээдүйн тогтвортой амьдралын үндэс билээ. Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэх хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын доройтол, цөлжилт зэрэг байгаль орчны тулгамдсан асуудлуудтай тэмцэж, энэхүү үйл хэрэгт Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) чухал үүрэг гүйцэтгэж байна. Тэдний тайланд дурдснаар “Бид хүн төрөлхтөн, байгаль дэлхийтэйгээ эв зохистой хамтран орших ирээдүйн төлөө яг одооноос эхлэн энэхүү харилцан уялдаатай сорилтуудыг шийдвэрлэж эхлэх хэрэгтэй байна. Энэ ирээдүйг бий болгох нь хамгаас чухал, хамгийн үнэ цэнтэй (<https://www.undp.org/mn>, 2024) хэмээн онцолсон байна. Иймд байгальтай нэгдэн орших уламжлалт ухааныг дэлгэрүүлэн мэдээлэх, бодлогын түвшинд тусгах нь тогтвортой ирээдүйн үндэс суурь болох юм. Байгаль бол зөвхөн орчин биш, оршихуйн утга, ирээдүйн баталгаа билээ.

### ***Шүтлэг шүтэн биширэхүй:***

Монголын уламжлалт Бөө мөргөл, Тэнгэр шүтлэг, Буддын шашин нь бүгд байгальтай харилцах гүн ухааныг агуулдаг.

Бөө мөргөл нь монголчуудын оршихуй, байгаль ертөнцийг ойлгох үзэлд гүн гүнзгий нөлөөлсөн. Чингэхдээ бөө мөргөлд дээд (тэнгэрийн хүч), дунд (хүний ертөнц), доод (өвөг дээдсийн сүнс) гурвыг нэгдэлтэй гэж үздэг

(Монгол зан үйлийн нэвтэрхий толь. Оюуны боть, 2020). Энэ нь бүх оршихуй хоорондоо салшгүй холбоотойг илэрхийлнэ.

**Мөн бөөгийн уламжлал ёсоор** уул, ус, мод, чулуу, амьтан бүрт “эзэн” байдаг. Бөө нар уул усны эзэдтэй харилцаж, тахил өргөснөөр байгаль ба хүний тэнцвэрийг хадгалдаг хэмээн үздэг байж. Ингэснээрээ хүний амьдрал зөвхөн өөрийн хүчинд бус, байгаль дэлхий, тэнгэрийн хүчтэй зохицоход тулгуурладаг хэмээн үзжээ. Монголчууд амь насыг тэнгэр олгож, бие цогцсыг газар олгодог гэж үзээд «эцэг тэнгэр», «эх газар» гэж дууддаг заншилтай байжээ. Иймээс бөө мөргөл нь оршихуйн нэгдлийг ухааруулах төдийгүй хүнийг байгаль, тэнгэр, газар, өвөг дээдсийн сүнстэйгээ салшгүй холбоотой амьтан гэдгийг сануулдаг сургаал юм. Ийнхүү бөө мөргөл нь оршихуйн нэгдлийг зөвхөн үзэл санаанд бус, харин өдөр тутмын амьдрал, зан үйл, ахуй соёлд шингээн хэрэгжүүлж ирсэн байна. Монголчуудын нүүдэллэж ирсэн аж төрөх ёс нь мал дагасан хэрмэл амьдрал байгаагүй. Харин амьтай амьгүй байгаль, хүмүүсийн амьдралын шүтэлцээ, зүй ёсыг дээдлэх ухааны үр байсан. Өвөг дээдэс маань газар нутгаа амь амьдралын уг үндэс хэмээн үзэж, өндөр сүрлэг нурууд, уул усаа хайрхан гэж, ус булгаа рашаан хэмээн дээдэлж, хөрс ургамал амьтнаа хайрлан хамгаалж иржээ. Энэ нь далдын хүчинд итгэсэн мухар сүсэг төдий биш байв. Харин ч байгаль хүний амьдралын шүтэлцээ, зүй ёсыг дээдлэх ухааны үр байсан. Энэ байдлыг уламжлалт бөөгийн шашинтай холбон үздэг. Бөөгийн шашны үүсэл бол байгалийн амьтан хүн, эх байгальтайгаа харьцах асуудалтай холбоотой. Хүн байгалийн харьцааг зохицуулах үйл явцад хамгийн анх өртсөн шүтлэгийн зүйл бол байгалийн элдэв амьтан, ургамал, хад чулуу, харсан тэнгэрийн тухай ойлголт байдаг хэмээн эрдэмтэн

О.Пүрэв “Монгол бөөгийн шашин” (О.Пүрэв, 2002) (Т.Сэнгэдорж, 1999) бүтээлдээ дүгнэсэн байдаг.

**Харин тэнгэр шүтлэг** нь монголчуудын оршихуй, байгаль ертөнцийг үзэх уламжлалд төв байр суурь эзэлдэг. Эртний нүүдэлчдийн хувьд “Мөнх тэнгэр” бол бүхнийг бүтээгч, оршихуйн дээд хууль, ертөнцийн дэг журмыг тогтоогч хүч байсан. Тэнгэрийг зөвхөн дээд хүч төдийгүй ёс суртахууны шүүлтүүр гэж ойлгож иржээ. Тухайлбал, төрийн эрх мэдэл, хааны суурь нь Тэнгэрийн ивээлд тулгуурласан гэж үздэг байсан бөгөөд “Тэнгэрийн зарлигаар хаан суусан” гэх ойлголт түгээмэл байв. Ийнхүү Тэнгэр шүтлэг нь зөвхөн шашин биш, харин нийгмийн зохицол, ёс суртахууны дэг журам, байгальтай зохицон амьдрах үзэл сургаал болж байлаа. Ийнхүү эх байгалиа хайрлах, оршихуйгаа эрхэмлэх хандлага Монгол уламжлалд гүн шингэсэн байжээ.

Монголчууд Буддын шашныг өөрийн нутагт идээшүүлэн хөгжүүлэх явцдаа “эх болсон зургаан зүйл хамаг амьтныг” энэрэн нигүүлсэх, хайрлах тухай сургаалыг айлдаж байсан.

Энэхүү сургаал нь амьтан, ургамал болон байгаль орчны бүх зүйлд энэрэлтэй хандах, аливаа юмсыг шүтэн барилдахуйн ухаанд цогцлоон авч үзсэн бөгөөд ингэснээр байгальтай нэгдмэл оршихуйг улам баяжуулсан юм. Мөн байгаль дэлхийг хайрлах ёс зүйн чиг баримжаагаар олон зууны турш ахуй амьдралд нь шингэсэн гэж үзэх үндэстэй.

**Түүхэн уламжлал, эх сурвалж:** Монголчуудын байгальтай харилцах уламжлалт хандлага нь зөвхөн зан заншил, ёс суртахуун төдийгүй төрийн бодлого, эрх зүйн тогтолцоонд том орон зайг эзэлж байсан. Түүхэн сурвалжууд, хууль цаазын бичгүүд, төрийн үзэл баримтлалд байгаль орчныг хамгаалах тухай ойлголт нь онтологи, ёс суртахуун,

эрх зүйн түвшинд баталгаажиг байгаль бол амьдралын эх сурвалж” гэсэн агуулгыг зангидсан нь харагддаг. Жишээ нь Модун шаньюй хаан “Газар бол улсын үндэс мөн” гэж айлдсан нь монгол төрийн байгаль хамгааллын бодлогын тулгуур болсон байна хэмээн Т.Сэнгэдорж судалгааны бүтээлдээ (Т.Сэнгэдорж, 1999) өгүүлжээ. Энд байгаль бол зөвхөн эдийн засгийн нөөц бус, төр, оршихуй, соёлын суурь гэдгийг тодотгож байна. Түүнчлэн Монголын нууц товчоо, Их засаг, Арван буянт номын цагаан түүх, Алтан хааны цааз бичиг, Халх журам зэрэг Монголын хууль цаазын бичгүүдэд байгаль хамгаалах зан заншил, байгаль орчноо хайрлан хамгаалах, зохистой ашиглахаар тод томруунаар тусгаж байжээ. Тухайлбал байгаль бодисийг хайрлуулах тухай “Хар татаарын тухай хэргийн товч”-д “Өвс ногоорсны хойно газрыг нүхэлсэн ба гал алдаж бэлчээрийг шатаагсдын нэг гэрийг алмой» гэж тэмдэглэсэн байдаг. Тэр ч байтугай Монголчуудын байгальд шудрага бус хандсанаас үүдэх хохиролыг хэрхэх тухай хууль цаазандаа сайтар тусгасан байдаг. 1206 онд Их Монгол улсад байгаль хамгаалах хууль цаазын нэгдмэл тогтолцоо бий болж энэ үеийн гол хууль нь “Их засаг хууль” байлаа. Эл хууль нь нийгмийн олон талын харилцааг зохицуулсан нэгдмэл хууль болж чадсан байна. Байгалийн зэрлэг амьтдын үржих өсөх тэнцвэрийг зохицуулах уламжлалын дотор зэрлэг ан амьтан агнах хандлага зан үйл багтах бөгөөд тэдгээрийг авлахдаа тэнцвэрт байдлыг харгалзан үздэг байжээ. Ан амьтны үржих, төлжих, үс арьс, тарга хүч гүйцэх цаг хугацааг нарийн танин мэдэж, зөв сонгон авч ан ав хийдэг, ангийн мах, арьс зэрэг олзвороо туйлаас хүндэтгэн, ариглан хэрэглэдэг байж. Олноороо ан гөрөөнд мордохдоо хүндэтгэлийн ёслол үйлддэг дэг жаяг байх бөгөөд зөрчих ахул зан заншлын төдийгүй хууль цаазын цээрлэл хүлээдэг

байжээ. Цицерон үзэхдээ “байгалийн хууль” гэдгийг тэрээр байгалийн болон хүний төрөлх мөн чанараас үүдэн гарсан жам ёсны зүйлийг эрх зүйн талаас нь тусгасан хэм хэмжээ гэж үзэж байв. Байгалын жам ёсны хуулийг хэн ч хэзээ ч өөрчлөх гэж оролдох ёсгүй. Байгалийн хуулиас үүдэн хүний бичмэл хууль гарч ирэх ёстой (Д.Болд-Эрдэнэ, 2015) хэмээн үзэж байсан. Монголчууд байгаль орчныг хамгаалах талаар хууль цааз бичгүүд болох “Их засаг”, “Халх журам”, “Арван буянт номын цагаан түүх”, “Монгол Ойрадын хууль”, “Зарлигаар тогтоосон монгол улсын хууль зүйлийн бичиг” болон Монгол улсын үндсэн хуулинд байгаль хамгааллын талаар хэрхэн тусч, хэрэгжиж байсан талаар судлаач О.Амархүү “Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз (уламжлал шинэчлэлийн асуудал)” УБ.,2000 гэсэн бүтээлдээ тод томруун авч үзсэн байна.

Монголчуудын байгальтай харилцах уламжлалт хандлага нь зөвхөн ёс суртахуун, зан заншлын хүрээнд хязгаарлагдаагүй, төрт ёсны үзэл, хэв хууль, сурвалж бичгүүдэд нь гүн бат сууж, төрийн оршихуйн үндэс, соёлын язгуур, амьдралын эх сурвалж болж байсан нь түүхэн эх сурвалжуудаар нотлогдож байна.

Энэ нь байгальтай зүй бус харьцахаас сэргийлсэн эрх зүйн хэм хэмжээг тогтоож, Байгальд шударга бус хандсан тохиолдолд зан заншлын төдийгүй хууль цаазын хариуцлага хүлээлгэдэг нь байгаль хамгааллын иж бүрэн тогтолцоо бүрэлдэн тогтсоны илрэл юм.

**Тэгэхээр монголчуудын байгаль хамгааллын уламжлал нь зөвхөн экологийн хэм хэмжээ, орчны тэнцвэрийг хадгалахад бас чиглэгддэггүй; харин хүн, байгаль хоёрын харилцан зохицлыг эрхэмлэн, оршихуй болон амьдралын утга**

**учиртай салшгүй холбоотой асуудал болж байдаг.** Иймээс оршихуй нь ямар нэг зүйл байж болох, оршиж болох бүхний нийтлэг нөхцөл ба утга юм. Харин хүний хувьд оршихуй нь байгаад зогсохгүй, утга хайх, эрх чөлөөтэйгээр сонгох, хариуцлага хүлээх үйл явц болж хувирдаг.

Философийн түүхэнд хүн байгалийн харилцааны тухай дараах байдлаар авч үзэж байжээ. Эрт үед Аристотель хүн ба байгаль хоёрын зохицлыг авч үзэхдээ, оршихуйг зорилготой (teleology) гэж тайлбарласан (Notre Dame Philosophical Reviews, 2011). Энэ нь ямар учраас энэ юм оршин буй юм бэ?, ямар утга учиртай вэ? гэсэн асуултыг тавьдаг. Ингээд амьдралын утга, оршихуйг тайлбарлах асуултаа тавьж, байгаль, хүн хоёр нэг “зорилгод нийцсэн” гээд бие биетэйгээ харилцан үйлчилж, оршихуйг утга учиртай болгодог гэдгийг илтгэсэн байна.

Дундад зууны үеийн философич Фома Аквинский хүний ёс зүй, бурханлаг бүтээл болон байгальтай холбогдсон ойлголтыг онцлон авч үзсэн бөгөөд ‘Grace does not destroy nature, but perfects it’ гэсэн үгнээс үзэхэд, бурханлаг хүч хүн ба байгаль хоёрыг устгах бус, харин тэднийг төгөлдөржүүлж, ёс зүй, эрхэм чанарыг нь гүнзгийрүүлдэг болохыг илэрхийлдэг. Ингэснээр хүн байгальд зөвхөн оршдог төдийгүй, байгальд хүндэтгэлтэй, зохистой хандлагаар хандан, оршихуйг утга учиртай болгох үүргийг илэрхийлжээ. (Theimaginativeconservative, 2025).

Шинэ үеийн Спиноза: “*God or Nature — being one and the same*” гэж үзэж, хүн ба байгаль нэгэн бүтээл, оршихуй бүрэн бүтэн байдлын хэсэг болохыг баталсан (<https://plato.stanford.edu/>, 2023). Спинозагийн пантеист философи нь хүнийг байгалиас ангид бус, нэгэн бүхэл оршихуйн хэсэг гэж үзсэнээр, орчин үеийн экологийн философи, ялангуяа

(deep ecology) гүний экологи чиглэлд онцгой хувь нэмэр оруулсан.

Харин Кант хүний ёс зүйн үүргээр дамжин байгаль хамгаалах зарчмыг дэвшүүлсэн: “*Act so that you treat humanity, whether in your own person or in the person of any other, always at the same time as an end, never merely as a means*” (Stanford, 2022) Энэ зарчим нь шууд утгаараа хүний эрхэм чанарыг хамгаалах тухай боловч цааш өргөжүүлбэл байгальтай харилцах хүний хандлагад ч хамаарч, байгальд хүндэтгэлтэй, зохистой хандах ёс зүйн суурь үзэл болж өгдөг. Өөрөөр хэлбэл, Кантын ёс суртахууны философи нь хүний өөрийн эрх ашгийг байгальд давамгайллуулах бус, харин хүн байгальд үүрэгтэй, байгаль бол ашиглах хэрэгсэл биш, харин хүний оршихуйн салшгүй нэг хэсэг гэсэн ойлголтыг дэмжих суурь болсон.

Философич Хайдеггер: “*Being-in-the-world is the basic state of Dasein*” хэмээн хүний оршихуйг дан ганцаараа бус, орчинтойгоо хамт орших байдал гэж тайлбарлаж, байгальтай харилцах боломжийг ухамсарлахад чиглэсэн (Researchgate, 2014) Энэ нь хүний оршихуй (Dasein) нь ертөнцөөс тусгаар бус, харин орчноо хамтад нь ойлгож, түүний дотор орших үндсэн “байхуй” болохыг илэрхийлдэг. Ийм ойлголтоор хүний бодит оршихуй нь байгаль, нийгэм, бусадтайгаа зайлшгүй харилцан хамааралтай бөгөөд зөвхөн хамтын нөхцөлд бүрэн төгс утга учиртай болж чадна. Хайдеггерийн энэхүү үзэл нь орчин үеийн экологийн ухамсар болон байгальтай харилцах философийн суурь хандлагад нөлөөлж, хүн байгальд “гадаад ахуйн хэрэглэгч” бус, харин “хамт оршихуй” гэсэн ойлголтыг гүнзгийрүүлсэн. Г.Сайнхишиг багшийн орчуулсан “Хайдеггерийн Энэ философи гэдэг юу вэ” гэдэг алдартай лекцийн монгол орчуулгын хэсгийн гар ноорог бидэнд байдаг. Тэндээс энэхүү

өгүүлэлийнхээ “оршихуйн нэгдэл” агуулгын хүрээнд багтах дараах санааг шүүрдэн эмхэллээ. Философи бол зөвхөн мэдлэг цуглуулах биш, харин “байгаа юм байгаа учраас байгаа юм юу вэ?” гэсэн үндсэн асуултад хариу эрэх, өөрөөр хэлбэл оршихуй (Sein)–н утгыг эрэх үйл хэрэг. Хариулт гэж юу вэ?: Хайдеггерийн хувьд “хариулт” гэдэг нь тодорхойлолт бус, харин оршихуйтай таарч нийцэх (Entsprechen) үйл явц. Өөрөөр хэлбэл философи бол ямар нэг систем бус, харин оршихуйтай харилцах “зам”. Философи бол зөвхөн рациональ үйл хэрэг биш, бас зөвхөн мэдрэмж биш. Тэр бол хүн ба оршихуйн гүн холбоонд оролцож, оршихуйг асуух замд алхах явдал юм гэдгийг бид олзуурхан дэмжиж байна. Ийнхүү Хайдеггерийн үзэл санааг түшиглэн үзвэл, философи бол энгийнээр мэдлэг хуримтлуулах, эсвэл онолын тогтолцоо бүтээх үйл ажиллагаанаас гадна хүний оршихуй ба ахуйн гүн холбоог мэдрэх, түүнтэй нийцэн орших зам юм. Тиймээс философи ёс суртахууны болон онтологийн чиг баримжаа олгох үйл хэрэг бөгөөд энэ нь “оршихуйн нэгдэл”-ийн тухай асуудлыг өнөөдөр ч дахин эргэн асуух зайлшгүй шалтгаан болж байна.

Арне Нэсс (Deep Ecology) байгаль нь өөрийн эрхтэй, хүнээс хамааралгүй оршихуй гэж үзээд: “*The right of all forms of life to live is a universal right*” хэмээн бүх амьдралын үнэ цэнийг хамгаалах нэгдмэл байдлыг онцолсон. (Researchgate, 2017). Арне Нэссийн гүний экологийн үзэл санаа нь байгаль орчны ёс зүйд хувьсгалт өөрчлөлт авчирсан бөгөөд тэрээр бүх амьд биетийн оршихуйн эрхийг “*The right of all forms of life to live is a universal right*” хэмээн тунхагласан. Энэ нь зөвхөн хүний ашиг сонирхолд нийцсэн байгаль орчныг хамгаалах бус, бүх амьд биетийн эрх, үнэ цэнийг хамгаалах ёс зүйн үндсийг тавьсан юм. Нэссийн гүний

экологийн үзэл нь хүний оршихуйг байгальтай салшгүй холбогдсон, бүх амьд биетийн эрхийг хүндэтгэх ёстой гэдгийг онцолдог. Тэрээр хүний “Self-realization” буюу өөрийгөө танин мэдэх үйл явцыг байгальтай холбогдсон байдлаар тайлбарладаг. Энэ нь хүний “би” нь зөвхөн өөрийгөө биш, харин бүх амьд биетийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт байх ёстой гэсэн санаа юм. Нэссийн үзэл санаа нь орчин үеийн экологийн ёс зүй, байгаль орчны хамгаалал, амьд биетийн эрхийг хүндэтгэх чиглэлд чухал нөлөө үзүүлсэн. Түүний гүн экологийн үзэл нь хүний байгальтай харилцах харилцааг дахин тодорхойлж, амьд биетийн эрхийг хамгаалах ёс зүйн үндсийг тавьсан юм.

Ийнхүү эртний үеэс орчин үе хүртэл философийн урсгалууд нь хүн ба байгаль, оршихуй хоорондын харилцааг ёс зүй, экосистемийн бүтэн байдал, ухамсар болон технологийн хөгжлийн уялдаатайгаар ойлгож, хамгаалах хандлагыг хөгжүүлж ирсэн нь тодорхой харагдана. Эдгээрээс харахад монгол уламжлал дахь хүн байгалийн хоорондын зохицлын тухай үзэл санаатай тодорхой түвшинд дүйж буй нь харагдаж байна.

#### **IV. СУДАЛГААНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Бидэнд өнөө цагт тулгамдаж буй байгаль орчинтой холбоотой олон асуудал үүссэн. Манайхны хувьд байгаль хамгааллын уламжлалаа нийгмийн шинэчлэл өөрчлөлтөөс үүдэлтэй өнгөрсөн 30 гаруй жил үндсэндээ гэсэн гэж үзэж болно. Үүний нэг жишээ нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй экологийн доройтол газар авсан. Энэ тухай бид 2022 онд Германы хамтын ажиллагаа нийгэмлэгийн ахлах зөвлөх, биологич, ландшафтын экологич Торстен Хардер “Монголын экосистемд нүүрлэж буй сүйрлийн аюул” - Байгаль

хамгаалалгүйгээр Алсын хараа-2050-д (<https://www.ulsturch.mn/>, 2022) хүрэх боломжгүй сэдвээр Байнгын хорооны гишүүдэд танилцуулга илтгэлээ тавьсныг онцлохыг хүслээ. Тэрхүү илтгэлд *Мөнх цэвдэг ба ой модны хувь заяа*: “Мөнх цэвдэг байгаагүй бол Монголд ой байхгүй байх байсан” Монгол орны ой мод нь хур тунадасаас илүү мөнх цэвдгийн тогтвортой байдалд түшиглэж ирсэн. Гэвч цэвдэг гэсэхийн хэрээр ой устаж, 2040 он гэхэд 50% нь алга болох эрсдэлтэй гэж анхааруулж байна.

*Бэлчээрийн доройтол ба мал аж ахуйн ачаалал*: “259 суманд бэлчээрийн даац хэтэрсэн... 50 жилийн өмнө 20 төрлийн ургамал ургаж байсан бол одоо тавхан төрлийн нэг наст хог ургамал ургаж байна” Бэлчээрийн даац хэтэрсэн нь экологийн тэнцвэрт байдалд ноцтой хохирол учруулж буй. Ургамлын төрөл зүйл буурах нь зөвхөн бэлчээрийн доройтол бус, цаашлаад малын махны чанар, хүнсний аюулгүй байдалд нөлөөлж байна.

*Хөрс ба усны доройтол*: “Монгол орны газар нутгийн 90 хувьд хөрс үүсэх процесс зогссон” Хөрс гэдэг бол дахин нөхөгдөшгүй баялаг. Нэгэнт алдагдвал хэдэн мянган жилээр ч сэргээгдэхгүй. “Гол мөрөн булингартай байгаа шалтгаан нь хөрс усаар угаагдан эргээж буцалтгүй алдагдаж байна” Усны чанар муудах, гол мөрөн ширгэхийн суурь шалтгаан хөрсний доройтол гэдгийг ил тод хэлсэн.

*Усны нөөцийн хомсдол ба Арал тэнгисийн жишээ*: “Монгол Улс нөхөн сэргээггүй усаа хэрэглээд эхэлсэн... Минийхээр Монгол Улс Арал тэнгистэй харьцуулишгүй том сүйрэл рүүгээ явж байна” Гүний усыг зохисгүй ашиглах нь Монголын хамгийн том экологийн аюул гэж тэр үзэж байна.

*“Монголчуудад байгалиа сэргээх боломж байгаа ч маш богино хугацаа үлдсэн. 2030 оныг өнгөрөөвөл ямар ч*

боломжгүй.” Үндсэн санаа бол цаг алдах эрхгүй. Байгаль хамгааллын арга хэмжээ өнөөдөр авахгүй бол ирээдүйд ямар ч технологи, хөрөнгөөр нөхөж чадахгүй.

Энд гэхдээ бидэнд Гарцыг санал болгосон нь *“Малын тоог 25 саяд хүргэснээр экологийн тэнцвэрт байдал тэнцвэржих боломж бий болно.”* Малын тоо толгойг эрс багасгах, Ус ба хөрсийг хамгаалах ургамалжуулах менежмент хэрэгжүүлэх, Байгалийн жам ёсны нөхөн сэргээлтийг дэмжих, *“Говьд мод ургуулна гэдэг шийдлээ эргэн харах хэрэгтэй”* Усны нөөц хомс бүсэд хиймэл ой байгуулах биш, харин байгаа ойг хамгаалах бодлого баримтлах ёстойг онцолсон.

Эцэст нь дараах айхтар том дүгнэлтийг хийжээ.

~ *“Монголын байгаль яг л эрчимт эмчилгээний тасгийн өвчтөн мэт байна”*

~ *“Одоо хандлагаа өөрчлөхгүй бол Монгол Улс Ази тивд хэзээ ч байгаагүй гамшигт өртөх болно.”*

Эндээс бид байгаль ганц “салбарын асуудал” биш, үндэсний аюулгүй байдлын үндсэн тулгуур гэдгийг анхааруулсан.

Монголын уламжлалт сэтгэлгээ, нүүдэлчдийн амьдралын философи нь хүн, байгаль хоёрын салшгүй холбоог илэрхийлж ирсэн. Байгаль бол зөвхөн хэрэглээний нөөц бус, хүний оршихуйн үндэс гэж үздэг байсан нь монгол ахуй, ёс заншил, хорио цээр, шүтлэгт гүн суусан. Харин орчин цагт экологийн доройтол, уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаа нь энэ нэгдлийг сарниулж, экосистемийн уналтыг түргэсгэж буйг шинжлэх ухааны судалгаагаар нотолж байна.

Монгол уламжлалт байгаль үзэхүй нь хүн ба байгаль салшгүй холбоотой гэсэн санааг агуулдаг бол Торстен Хардэрын илтгэл нь энэ холбоо өнөөдөр тасрахын ирмэг дээр ирснийг

шинжлэх ухааны баримтаар харуулж байна.

Тэгэхээр экосистемд нүүрлэж буй эл асуудал нь хүний оршихуй, нийгмийн хандлага, ёс суртахууны хямралын илрэл юм. Философичдын үүрэг нь онолын тайлбар, шүүмжлэлээс илүүтэй, нийгмийн ухамсрыг өөрчлөх, соён гэгээрүүлэхэд чиглэх шаардлагатай.

Байгаль бол хүний өмч бус, хамтын оршихуй гэдгийг онолын түвшинд батлан, ирээдүй хойч үеийн өмнө хүлээх ёс суртахууны үүргийг тодотгох нь чухал (Jonas, 1979) хэмээн авч үзжээ. Монголчуудын уламжлалт байгаль хамгаалах зан үйл, ёс суртахууны шинжтэй төлөвшил, хүмүүнлэг хандлага бол эцсийн дүндээ байгаль хамгаалах сэтгэлгээний илрэл байсан юм. Соён гэгээрүүлэгч Д.Урианхай “Соёл иргэншлүүдийн ач холбогдол нь цаашдаа хүний бие махбодийн хэрэгцээг хангах чадавхи, ашиг тусаараа үнэлэгдэхээс илүү байгаль орчинтой яаж нөхцөлдөж, яаж зохицолдож, байгалийн ахуй, зүй тогтлыг хэрхэн хадгалж, өөртөө ч эерэг, экологид ч эерэг, үнэмлэхүй эерэг “эгэх холбоо”-нд ашиглах болон ашиглагдах чадвараараа үнэлэгдэж хэмжигдэнэ (Д.Урианхай, “Бодь сэтгэл, эв хамт ёс” Ганцаарчилсан хөдөлгөөн улс төрийн үзэл онолын “Очир” үнэнээс онцолсон Зэндмэнэ, 2005) гэжээ. Байгаль орчин нь хүний нийгмийн оршин тогтнох цаашид хөгжих, эцэст бүрэн төгөлдөрж анхдагч нөхцөл, үндсэн “материал” тул ...бүтээсэн энэ өгөгдөхүүнтэй харилцах харилцаа зохицол л алив соёл иргэншлийн жинхэнэ үнэлүүр, хэрэгцээ, ач холбогдлыг тодорхойлох болно (Д.Урианхай, “Бодь сэтгэл, эв хамт ёс” Ганцаарчилсан хөдөлгөөн улс төрийн үзэл онолын “Очир” үнэнээс онцолсон Зэндмэнэ, 2015) хэмээжээ.

Хувь хүнд байгаль хамгаалах үзэл санааг хэрхэн суулгах вэ?

Хүмүүсийн хэрэглээ, амьдралын хэв маягийг шүүн гунгааснаар экосистемийн тэнцвэрт байдалд бодит нөлөө үзүүлнэ. “Ерөөсөө ч, нийгмийн хөгжлийг оршихуйн хэлбэр буюу биежүүлж буй утга санааны талаас төдийгүй хүрсэн ойлголт ухаарлын төвшин, ахуйд шингээсэн мэдлэг, оюуны утга агуулга талаас нь авч үзэж, үнэ цэнэт зүйлсийг зөвхөн эдийн соёлд хамааруулах биш оршихуйн утга санааг хэрхэн бүтээн цогцлуулж байгаагаас нь ч эрж хайх нь зүйтэй. Энэ нь эцсийн бүлэгт хүмүүсний оршихуйн ирээдүй хүн-байгаль-нийгмийн зохицолт харилцааны тогтнохуй “эрхийг” тодорхойлох боломжийг нээхэд дөхөм болох учиртай (Л.Дашням, 2020) хэмээн соён гэгээрүүлэгч Л.Дашням “Язгуураа танихуйн өчүүхэн дусал” бүтээлдээ авч үзэхийн сацуу Монголчууд байгаль дэлхийгээ хайрлах агуу сайхан үлгэрлэлийг бий болгосон. “Үржих эх, өсөх нялхасыг бүү хөнөө”, “амьд амьтныг хороовол амьсгалаас бусдыг нь ашигла”, “хоёрын нэгийг үлдээ, хорлохоос өмнө ачлахыг бод” гэдэг нь монголчуудын хэрэглээний удирдамж болж иржээ. “Барж идэхээс мэрж ид” гэдэг бол монголчуудын байгаль хамгаалах арга ухаан юм гэдгийг онцлон дурдсан байна. Хувь хүний түвшинд байгаль хамгаалах ухамсар суулгахын тулд зөвхөн хууль дүрмээр биш, амьдралын хэв маяг, хэрэглээний соёлд нэвчсэн ёс суртахуун, оршихуйн утга санаа чухал болохыг ийнхүү онцолсон нь цаг үеэ олсон санаа юм. Түүний “нийгмийн хөгжлийг зөвхөн эдийн соёлын талаас бус, оршихуйн утга санааны бүтээл, оюуны агуулгын талаас нь эрэх ёстой” гэсэн байр суурь нь өнөөдөр ч үнэ цэнтэй хэвээр байна. Монголчуудын уламжлалт сургаал (“үржих эх, өсөх нялхасыг бүү хөнөө”, “хоёрын нэгийг үлдээ” гэх мэт) нь хэрэглээг зөвшөөрөх боловч хязгаарлах, хэмнэх, тэнцвэрийг сахих зарчмыг зааж

өгдөг. Энэ бол зөвхөн хэрэглээний удирдамж бус, цаашилбал экологийн ёс зүйн философийн үндэс болж байна. “Барж идэхээс мэрж ид” гэх ухаарал бол монголчуудын ахуйд шингэсэн байгаль хамгаалах арга ухааны товч, ухаалаг томъёолол юм. Иймээс хувь хүн байгаль хамгаалах хандлагаа төлөвшүүлэхдээ уламжлалт сургаалаа орчин үеийн хэрэглээний соёлд нийцүүлэн хэрэгжүүлэх нь чухал болно.

Экзистенциализмын үүднээс авч үзвэл, хүн төрөлхтөн байгальтай харилцахдаа хариуцлага хүлээх ёстой субъект бөгөөд байгальтайгаа үл тоомсорлон, дан ганц хэрэглээний үүднээс хандах нь оршихуйн хямралын нэгэн илрэл юм. Эрдэмтэн А.Цанжид авч үзснээр “Хүн бол сав шим ертөнцийн эзэн биш, уул ус, ургамал амьтантай зэрэгцэн оршиж, хамтран амьдрах учиртай амьд байгалийн нэг л тодорхой төрөл зүйл аж. Сав шим ертөнцтэй харилцахдаа тэндээс дураараа авч хэрэглэх ёстой эзний ёсоор бус, уул усны эзнээс нь зөвшөөрөл эрж” хэрэгтэй зүйлээ авч ашиглах ёстой. Энэ бол байгалийн эрхшээлд бүрэн байдаг гэсэн үг хараахан бус, зүй зохис тун хэмжээний тухай асуудал юм гээд цааш өгүүлэхдээ Монголчуудын ертөнцийг үзэх үзэлд хүн бол байгалийн эзэн юм уу ноён гэх, байгаль дэлхийг хэн нэгэн бүтээсэн идэвхигүй зүйл учраас түүнийг яаж ч хэрэглэж болно гэх үзэл байсангүй. Харин дасан зохицохуйн үүднээс байгаль дэлхийгээ ажиглах, харьцуулах, бясалгах замаар танин мэдэж, мэдсэнийхээ хэрээр аж төрөх оновчтой арга хэрэгслийг буй болгон зохицож иржээ. Хамтаар оршихуй буюу англи хэлээр “coexistence” хэмээн орчуулж болох оршин байхуйн энэхүү зарчим нь нүүдэлч малчдын сэтгэлгээний чухал ололт юм (Монгол үндэстний гүн ухаанч сэтгэлгээ, 2024) хэмээжээ. Эндээс харахад, Байгаль орчныг зөвшөөрөлтэй, хүндэтгэлтэй, хязгаартай хэрэглэх нь

өнөөдөр дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын доройтол, цөлжилт зэрэг сорилтуудтай нүүр тулж буй үед үнэт сургамж, бодлогын загвар болохуйц чадамжтай.

Ер нь манай судлаачид, философичид хүмүүнлэгийнхэн ирээдүйн төсөөлөл бий болгож, хүн ба байгаль зохицон орших санааг хэлэлцэн боловсруулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Энэ тухай Мартин Хайдеггерийн 1962 онд танилцуулсан “Цаг хугацаа ба оршихуй” (On Time and Being) лекц нь оршихуйн мөн чанарыг шинжлэхдээ байгаль орчны асуудлыг онолын төвшинд хөндсөн байдаг. Түүний үзэж буйгаар, орчин үеийн нийгэм байгаль дэлхийг “техникийн үзэл” (technological enframing) дагуу үзэж, түүнийг зөвхөн хүний хэрэгцээнд зориулагдсан нөөц мэт ойлгох хандлага нь экосистемийн доройтол, байгалийн баялагийн хэт ашиглалт зэрэг асуудлыг үүсгэж байна. Энэ тухай судлаач Н.Сарантуяа бичихдээ: “Орчин үеийн хүмүүний үйл бүтээлийн технологи нь гагцхүү хүрээлэн буйг ертөнцийг өөртөө ашигтайгаар өөрчлөн хувиргахад чиглэж байна.... технологийг бүтээхдээ хүрээлэн буй байгалийн ба нийгмийн орчныг хүмүүний өөрийнх нь ямагт амьдрах хүн орчинд нь сөргөлдүүлэн харшилдахгүй байх арга ажиллагааны зарчим байх шаардлагатайг онцгойлон анхааруулж байна. Үүний дотор ялангуяа хүмүүний амьд орших нөхцлийн суурь болж өгдөг байгаль орчныг сүйтгэхгүй байх арга ажиллагааны зарчим чухал болж байна (Н.Сарантуяа, 2010) гэжээ. Эндээс үзэхэд философичдын үүрэг нь зөвхөн онолын санаа бүтээх биш, ирээдүйн амьдралын онцгой шаардлага, оршихуйн зарчим, ёс суртахууны практикийг тодорхойлох явдал юм. Тэд хүн ба байгаль хоорондын харилцаанд урт хугацааны, тогтвортой зохицолт бий болгох санааг төлөвлөж, нийгэмд дамжуулах үүрэгтэй.

## V. ДҮГНЭЛТ

Байгаль орчинд учруулсан хүний олон олон зохисгүй үйлдлээс сургамж авч хүн байгалийн харилцаа холбооны асуудалд болон эх байгалиа хэрхэн хайрлан хамгаалж хишиг буяныг нь яаж зүй зохистой хэрэглэх вэ гэдэгт анхаарлаа хандуулж, Монголчуудын уламжлалт ертөнцийг үзэх үзэл, байгальтай харилцах уламжлал нь зөвхөн соёлын өв биш, ирээдүйн тогтвортой амьдралын суурь зарчим юм. Энэ зарчмыг орчин үеийн бодлого, боловсрол, судалгаанд тусган хэрэгжүүлэх нь оршихуйн ирээдүйг бүтээх чухал алхам билээ.

Хятадын философич Лао-з байгалийн хуулиудыг зайлшгүй мэдэж, зан төлөвөө түүнд зохицуулах ёстой гэжээ (Ю-Лань, 2003). Тэрээр үүнийг “гэгээрлийг” дагах гэж нэрлэсэн байдаг.

XVII зууны соён гэгээрлийн үеийн философич Б.Спиноза байгаль бол өөрийн жам хуулиар явдаг хүн бол тэр жам хуулийн нэг л хэсэг бөгөөд байгалиас хүнийг илүүд үзээгүй. Спиноза бүтээлдээ бурхан гэдэг үгийг их хэрэглэсэн энэ нь яг тэр үедээ түгээмэл хэрэглэдэг байсан бүтээгч бурханы тухай биш, харин байгалийг дурдсан хэрэг байлаа. Хятадын философич Лао-з байгалийн хуулиудыг зайлшгүй мэдэж, зан төлөвөө түүнд зохицуулах ёстой гэжээ.

Академич Ч.Жүгдэр монголчуудын байгалийг шүтэх шүтлэг нь юмсыг танин мэдэх, эхний шатанд нэгтгэн дүгнэх гэсэн оролдлого байжээ гээд “хүн байгалийг өдөр бүх ажиглаж, түүний юмс үзэгдэлтэй байнга учрах явцдаа хүний амьдралын бүх үйл ажиллагаа, түүний сайн муу бүх тал байгалиас бүрэн хамаарч байгааг олж үздэг байна. эндээс хүн ба аливаа бүх юмсын амьдрал үхлийн эзэн нь байгаль өөрөө юм гэсэн бодол төрдөг байна” (Ч.Жүгдэр, 2006) гэжээ. Энэ мөн л монголчуудын байгалиа хамгаалж, хайрлах тухай, хүнийн амьдралын мөн

чанарыг байгальтай шүтэлцүүлж ойлгож ирсэн уламжлалыг тусгасан байна.

Түүнчлэн 1972 онд зохион байгуулагдсан НҮБ-ын Байгаль орчны тухай Стокгольмын чуулган нь дэлхийн анхны томоохон хэмжээний байгаль орчны асуудлыг хөндсөн олон улсын хурал байсан бөгөөд тэндээс гарсан баримт бичигт “Дорно дахины ард түмний байгаль хамгаалах уламжлалаас өнөөдөр бид суралцах цаг болжээ” гэж онцолсон байдаг нь өнөөдөр ч хүчин төгөлдөр хэвээр юм. Үүний дараагаар гарсан 1982 оны Найробигийн тунхаглал, 1992 оны Рио де Жанейрогийн Байгаль орчны ба Хөгжлийн тунхаглал, 1997 оны Киотогийн Протокол, 2000 оны Мянганы Хөгжлийн Зорилтууд (MDGs), 2015 оны Тогтвортой Хөгжлийн Зорилтууд, Парисийн хэлэлцээр зэрэгт ч байгальтай зохицон орших, уламжлалт мэдлэгийг үнэлэх, тогтвортой хөгжлийг дэмжих, хамтын ажиллагааг чухалчлах гэсэн нийтлэг зарчмуудыг тодотгосон байдаг. Эдгээр нь Монголчуудын байгальтай нэгдэн орших уламжлалт хандлагатай огтлолцож буй нь бидний байгальд хандах уламжлалт арга ухаанаа илүү хариуцлагатайгаар авч хэрэгжүүлэх ёстойг мэдрүүлсэн байна гэж үзэж болно.

Байгаль бол зөвхөн эдийн засгийн нөөц бус, монгол хүний оршихуйн үндэс гэдгийг нийгмийн ухамсарт гүн суулгах нь философийн оруулж чадах хамгийн том хувь нэмэр юм.

#### Ашигласан материал

- Д.Болд-Эрдэнэ. (2015). *Улс төрийн философи*. Улаанбаатар.
- Д.Урианхай. (2005). “Бодь сэтгэл, эв хамт ёс” Ганцаарчилсан хөдөлгөөн улс төрийн үзэл онолын “Очир” үнэнээс онцолсон Зэндмэнэ. Улаанбаатар.
- Д.Урианхай. (2015). “Бодь сэтгэл, эв хамт ёс” Ганцаарчилсан хөдөлгөөн улс төрийн үзэл онолын “Очир” үнэнээс онцолсон Зэндмэнэ. Улаанбаатар.

- Л.Дашням. (2020). *Язгуураа танихуйд өчүүхэн дусал*. Улаанбаатар.
- Монгол зан үйлийн нэвтэрхий толь. *Оюуны боть*. (2020). Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Монгол үйлийн нэвтэрхий толь. (2020). Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Б.Пүрэвсүрэн (ed.). (2024). *Монгол үндэстний гүн ухаанч сэтгэлгээ*. Улаанбаатар: Содпресс.
- Н.Сарантуяа. (2010). *Монголын соёл-урлаг, шинжлэх ухаан, боловсрол: соёлын судалгааны утга зүйд*. Улаанбаатар.
- О.Пүрэв. (2002). *Монгол бөөгийн шашин*. Улаанбаатар.
- Т.Сэнгэдорж. (1999). *Экологийн эрх зүйн уламжлал, шинэчлэл*. Улаанбаатар.
- Ч.Жүгдэр. (2006). *Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил*. Улаанбаатар.
- Ю-Лань, Ф. (2003). *Хятадын философийн товч түүх*. Улаанбаатар.
- Being and Time*. Retrieved from [https://en.wikipedia.org/wiki/Being\\_and\\_Time](https://en.wikipedia.org/wiki/Being_and_Time)
- (1972, June 16). *United Nations Conference Document*. Retrieved from <https://docs.un.org/en/A/CONF.48/14/Rev.1>
- (2011, May 11). *Explanation and Teleology in Aristotle's Science of Nature*. Retrieved from [https://ndpr.nd.edu/reviews/explanation-and-teleology-in-aristotle-s-science-of-nature/?utm\\_source=chatgpt.com](https://ndpr.nd.edu/reviews/explanation-and-teleology-in-aristotle-s-science-of-nature/?utm_source=chatgpt.com)
- (2014, January). *Being in the World as Being in Nature: An Ecological Perspective on Being and Time*. Retrieved from [https://www.researchgate.net/publication/274136920\\_Being-in-the-World-as-Being-in-Nature-An-Ecological-Perspective-on-Being-and-Time](https://www.researchgate.net/publication/274136920_Being-in-the-World-as-Being-in-Nature-An-Ecological-Perspective-on-Being-and-Time)
- (2017, May). *The Shallow and the Deep Long-Range Ecology Movement*. Retrieved from [https://www.researchgate.net/publication/344740890\\_The\\_Shallow\\_and\\_the\\_Deep\\_Long-Range\\_Ecology\\_Movement](https://www.researchgate.net/publication/344740890_The_Shallow_and_the_Deep_Long-Range_Ecology_Movement)
- (2022, November 3). Retrieved from <https://www.ulsturch.mn/a/54185>
- (2022, January 21). *Kant: Moral Philosophy*. Retrieved from

- <https://plato.stanford.edu/entries/kant-moral/>  
(2023, November 8). *Spinoza*. Retrieved from [https://plato.stanford.edu/entries/spinoza/?utm\\_source](https://plato.stanford.edu/entries/spinoza/?utm_source)
- (2024, October 20). Retrieved from <https://www.undp.org/mn/mongolia/stories/mongol-ulsyn-togtvortoy-ireeduyn-toloo-uur-amsgalyn-oorchlolt-biologiyn-olonyanz-baydlyn-doroytol-colzhilttey-temcekh-n>
- (2025, May 28). *Gestell*. Retrieved from <https://en.wikipedia.org/w/index.php?title=Gestell&action=history>
- (2025, January 27). *Nature, Grace, Role, Reason, Life, Faith*. Retrieved from [https://theimaginativeconservative.org/2025/01/nature-grace-role-reason-life-faith.html?utm\\_source](https://theimaginativeconservative.org/2025/01/nature-grace-role-reason-life-faith.html?utm_source)
- (2025, July 14). *Bruno Latour*. Retrieved from [https://en.wikipedia.org/w/index.php?title=Bruno\\_Latour&action=history](https://en.wikipedia.org/w/index.php?title=Bruno_Latour&action=history)